

Угаалгын машин, тоног төхөөрөмжтэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилга

1. Машин тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллахаас гадна, тос, тоосыг үргэлж арчиж, газардуулгыг байнга шалгана.
2. Ажил эхлэхээс өмнө машиныг ажиллуулах цахилгаан хэрэгсэл товчлуур зэргийн бүрэн бүтэн байдлыг шалгана.
3. Тоног төхөөрөмжтэй харьцахдаа тухайн төхөөрөмжийн хөдлөгч эд ангид орооцолдох эд хэрэглэл, хувцас өмсөхийг хатуу хориглоно. Үүнд: хормой урттай, нэлмэгэр хувцас, монгол дээл, урт үс, гэзэг, хүзүүний зүүлт, ороолт гэх мэт
4. Нойтон гар, хувцастай цахилгаан хэрэглэлтэй харьцаж болохгүйг анхаарах
5. Ямар нэг эвдрэл гарвал өөр янзын дуу, цохих чимээ гарвал тоног төхөөрөмжийг яаралтай унтрааж, цахилгаанчин дуудаж засуулсаны дараа ажиллуулна.
6. Угаагч машинд ажиллагч нь тухайн машиныг ажиллаж байхад нь хаалгыг онголийгох цэвэрлэгээний материал хийх угаагч нунтаг хийхийг хатуу хориглоно.
7. Мушигч машиныг ажиллаж байхад нь тагыг онгойлгох ажлын барбаны эргэлтийн хүчийг гараар сааруулах зэргийг хатуу хориглоно.
8. Индүүн дээр ажиллагч нь шилбүүрэн "стоп" товчийг ажиллаж буй эсэхийг заавал шалгаж байж ажил эхлэнэ.
9. Халаагч плитаг ороогч эд ангиас тусгаарлахдаа заавал машиныг зогсоосон байна.
10. Хэрэв эвдрэл гарсаныг мэдсээр байж, тоног төхөөрөмжийн засварын хүн дуудаж үзүүлээгүй ажиллуулсан тохиолдолд уг хохиролыг тухайн хүнээр телүүлнэ.
11. Ажил дууссаны дараа машин тоног төхөөрөмжийн тоос, тосыг сайтар хуурай болтол арчиж, хажуу болон ойр хавийн усыг шавхаж арчина
12. Машин тоног төхөөрөмжийг дур мэдэн задлах, засах гэж оролдох, технологийн горим зөрчих, ачаалал ихдүүлж ажиллуулахыг хориглоно.